



ТА ХУВЬЦААНЫ
ДАНСАА НЭЭЛГЭСЭН ҮҮ?

ХУВЬЦААНЫ ЦАГААН ТОЛГОЙ

ГАРЧИГ

БҮЛЭГ I

ХАНГАЛТТАЙ ОРЛОГО БА ХУВЬЦАА	7
Та аз жаргалтай амьдрахыг хүсч байна үү?	8
Та 1072 хувьцаагаа яах гэж байна?	10
Хувьцаагаа авахын тулд яах хэрэгтэй вэ?	13
Хүн бүрийн асуудаг асуултууд	14
Хувьцаа гэж юу вэ?	16
Энгийн хувьцаа	18
Давуу эрхийн хувьцаа	19
Хувьцаа эзэмших ямар давуу талтай вэ?	20
Таны мөнгө өссөн үү?	24
Хувьцаа эзэмшигч болвол ямар эрх эдлэх вэ?	28
Ногдол ашиг	29
Хувьцаа эзэмшигчдийн бусад эрх	32

БҮЛЭГ II

АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЦАГ ИРЛЭЭ	35
Хувьцааг хаанаас худалдаж авдаг вэ?	36
Брокер дилерийн компани ямар үүрэгтэй вэ?	38
Ямар брокер дилерийн компанийг сонгох нь зөв бэ?	39
Арилжаанд оролцох алхмууд	41
Захиалга өгөхдөө юуг анхаарах вэ?	45
Данснаасаа бэлэн мөнгө авах	48
Хувьцаа худалдан авахдаа юуг анхаарах вэ?	49
Хувьцаа хүмүүсийн амьдралд	54

БҮЛЭГ III	
ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ	57
Үнэт цаасны зах зээл гэж юуг хэлдэг вэ?	58
Анхдагч ба хоёрдогч зах зээл	59
Үнэт цаасны тухай	60
Индекс гэж юу вэ?	62
Үнэт цаасны зах зээлд оролцогчид	63
ҮЦТТТХТ	64
Андеррайтер	65
Хөрөнгө оруулалтын зөвлөх	66
Хувьцаагаар баяжсан хүмүүсийн түүхээс	68

БҮЛЭГ IV	
БОНДЫН ҮР АШИГ	75
Бонд гэж юуг хэлдэг вэ?	76
Ямар төрлийн бондууд байдаг вэ?	77
Бонд эзэмшихийн давуу болон сул тал	79
Бонд худалдан авахад юуг анхаарах вэ?	80
Хувьцаа болон бондын ялгаа	83

БҮЛЭГ V	
ТА БА ТАВАН ТОЛГОЙ	85
Таны мэдэх учиртай Тавантолгой	86
Тавантолгой ордын түүх	87
Эрдэнэс Тавантолгой ямар компани вэ?	90

БҮЛЭГ I

**ХАНГАЛТТАЙ
ОРЛОГО БА
ХУВЬЦАА**



ЯАЖ ХАНГАЛТТАЙ ОРЛОГОТОЙ БОЛОХ ВЭ?

Бүгд л ингэж боддог.
Та ч гэсэн яг одоо
ингэж бодож байна уу?

ОДОО БОДОЖ ГҮЙЦЛЭЭ. ХАМТДАА ХИЙЦГЭЭЕ!!!

Хүслээ биелүүлж, хүрэлцэхүйц мөнгөтэй болж, аз жаргалтай амьдрахын тулд юунаас эхлэх вэ?

- А. Бизнес эрхлэх үү?
- Б. Мөнгөө хадгалах үү?
- В. Гадаад явж ажил хийх үү?
- Г. **Хувьцаа авах уу?**

- Хөрөнгө мөнгө хэрэгтэй.
- Инфляцид идэгдэхээс айж байна.
- Хэтэрхий их эрсдэлтэй юм.
- **Харин ээ....?**



Харин ээ... бишээ.

**ТИЙМЭЭ, ТА 1072
ХУВЬЦААГАА
ЯАХ ГЭЖ БАЙНА?**

ЭРХ АШИГ ТАНЬ ХӨНДӨГДСӨН ГЭЖ ҮЗВЭЛ ХААНА ХАНДАХ ВЭ?

Үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө шаардлагатай болон хөрөнгөө өсгөх сонирхолтой талууд мөн тэдгээрийн дунд мэргэжлийн зуучлагч байгууллагууд ажилладаг тухай та мэддэг болсон.

Харин одоо хэрвээ хувьцаа эзэмшигч таны эрх ашиг ямар нэг байдлаар хөндөгдвөл хаана хандах вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байгаа байх.



Манай улсад хөрөнгө оруулагч таны эрх ашгийг хамгаалдаг байгууллага нь анх “Үнэт цаасны хууль” 1994 онд батлагдан гарснаас хойш 2 сарын дараа Үнэт цаасны хороо нэртэй байгуулагдаж байсан бөгөөд 2006 оноос хойш Санхүүгийн зохицуулах хороо нэртэй ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн дагуу санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч талын эрх ашгийг хамгаалах гэсэн үндсэн үүрэгтэй ажилладаг бөгөөд үүнд үнэт цаасны зах зээл ч үүнд багтдаг.

Та үнэт цаасны зах зээлтэй холбоотой аливаа маргаантай асуудлаар энэхүү төрийн байгууллагад хандаж болно.

Эрдэнэс Тавантолгойн хувьцааг иргэдэд үнэгүй эзэмшүүлэхтэй холбоотойгоор **иргэд үнэт цаасны зах зээлийг сонирхох нь нэмэгдсэний зэрэгцээ цэнхэр, ягаан тасалбарын асуудлаар сүүлийн үед уг байгууллагад хандах иргэдийн тоо олширч байгаа ажээ.**

БҮЛЭГ II

**АРИЛЖААНД
ОРОЛЦОХ
ЦАГ ИРЛЭЭ**

ХУВЬЦААГ ХААНААС ХУДАЛДАЖ АВДАГ ВЭ?

**Хувьцааг хөрөнгийн
биржид арилждаг.**


“Тэгвэл хөрөнгийн
биржид юу болдог вэ
гэдгээс эхэлье.



Сүхбаатарын талбайн баруун талд Монголын хөрөнгийн бирж бий. Гэхдээ хөрөнгийн бирж тэнд байдгийг мэддэггүй хүмүүс ч бий. Үүнд гайхах юмгүй л дээ. Хөрөнгийн бирж, үнэт цаас, хувьцаа гэдгийг ямар нэгэн санхүүгийн сургууль төгссөн зангиатай залуугийн ярьдаг зүйл гэж зарим хүмүүс одоо ч төсөөлсөөр байгаад л хамаг учир байгаа юм.

- Хөрөнгийн биржид юу болдог бол гэж та хэзээ нэгэн цагт бодож байсан уу?


- **Тэгвэл тэнд тань шиг хүмүүс хувьцаа худалдан авч ашиг орлогоо нэмэгдүүлж байдаг юм.** Энэ бол нэгэн төрлийн арилжаа. Хүмүүс өдөр тутамдаа ямар нэгэн зүйлийг худалдаж, худалдан авч байдгийн л ижил энгийн зүйл.



1995 оны 8 дугаар сарын 28-ны өдөр үнэт цаасны хоёрдогч зах зээл арилжаагаа эхлүүлж Монгол Улсад үнэт цаасны зах зээл жинхэнэ утгаараа хэрэгжих боломжтой болсон юм. Өнгөрсөн хугацаанд Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаа болон бонд гэсэн үнэт цаасны зах зээлийн үндсэн хэрэгслүүд арилжигдаж иржээ.

ХУВЬЦАА ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛД

АЖЛЫН БУЯН 15 САЯ ТӨГРӨГ



Эрдэнэс Тавантолгойн 536 ширхэг хувьцааг иргэдэд эзэмшүүлэх мэдээллийг аваад манай хамаатны ах маань дансаа нээлгэхээр брокер дилерийн компани дээр очтол данстай байна гэсэн мэдээлэл гарав.

Өмнө нь ажиллаж байсан компанийнх нь хүсэлтээр түүний данс нээгдсэн гэдгийг ч дуулгав. Хамаатны ах маань Шарын голд ажиллаж байсан бөгөөд анх өмч хувьчлалын үеэр Шарын гол ХК ажилчиддаа данс нээлгэж, хувьцаа олгож байсан байна. Түүний дансанд 536 хувьцаанаас гадна 560 хувьцаа байсан нь ажиллаж байсан Шарын гол ХК-ийнх нь байжээ.

Ахыг хувьцаатайгаа мэдсэн өдөр буюу 2011 оны 2-р сарын 20-нд Шарын гол ХК-ийн хувьцааны үнэ 27,980 төгрөг байсан бөгөөд ах маань брокер дилерийн компанидаа зарах захиалга өгч, нэг өдрийн дараа гэхэд л 15,668,800 төгрөгтэй болсон юм даа. Ах зарах захиалгаа өгчхөөд нэг өдрийг их л догдолж өнгөрөөж билээ.



ГЭНЭТ 28 САЯ ТӨГРӨГТЭЙГӨӨ МЭДСЭН НЬ



Эрдэнэс Тавантолгойн хувьцааны сургаар Оргил дансаа нээлгэхээр нэгэн брокер дилерийн компани дээр очтол брокер эмэгтэй түүнийг данстай юм байна хэмээн хэлсэн байна.

Оргил 30 гаруй наслахдаа хувьцааны тухай нэг ч удаа сонирхож байгаагүй бөгөөд яагаад данс нээгдсэнийг гайхаад олсонгүй. Гэртээ ирээд энэ тухайгаа хэлтэл Оргилын аав, ээж их хувьчлалын үед цэнхэр, ягаан тасалбараа нэгэн брокерийн пүүст аваачиж бүртгүүлж байсан гэсэн яриа өрнөжээ.

Оргилын данс цэнхэр, ягаан тасалбарын буюу хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн данс болох нь тодорхой болсон байна. Оргилын дансанд Эрдэнэс Тавантолгойн 536 хувьцаанаас гадна 28 ширхэг хувьцаа байлаа. Гайхалтай нь Оргил данстай байгаад зогсохгүй бичиг баримтаа авч очин хуулгаа үзэхэд дансанд нь 28 сая төгрөг байсан явдал юм.

Оргилын дансанд байсан 28 ширхэг хувьцаа нь жижиг Тавантолгой буюу Тавантолгой ХК-ийн хувьцаа байв. Тавантолгой ХК нь улсын үйлдвэрийн газар байгаад 1992-1995 оны өмч хувьчлалаар хувьчлагдсан бөгөөд тэр үед Оргилын ээж нь цэнхэр тасалбараараа уг компанийн 28 ширхэг хувьцааг авсан байжээ.

Оргилын ээжийг авах үед нэг ширхэг нь 80-100 төгрөг байсан хувьцаа 2011 оны 2-р сард нэг сая орчим төгрөг болж, нийт үнийн дүн нь 28 сая төгрөг болсон байв. Тэдний гэр бүлийнхэн ингэж нэг л өдөр 28 сая төгрөгтэй болж хагартлаа баярласан юм.



БҮЛЭГ III

**ҮНЭТ
ЦААСНЫ
ЗАХ ЗЭЭЛ**

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ГЭЖ ЮУГ ХЭЛДЭГ ВЭ?

Үнэт цаасны зах зээл дээр үндсэндээ хувьцаа, бонд болон эдгээр дээр суурилсан гуравдагч буюу үүсмэл үнэт цааснууд арилжигддаг. Өөрөөр хэлбэл хувьцаа, бонд болон үүсмэл үнэт цаас гэсэн 3 төрлийн үнэт цаас байдаг.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ гэдэг нь үнэт цаас гаргах, бүртгүүлэх, арилжих, хадгалах, түүгээр гэрчлэгдсэн **ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦАА ЮМ.**

Өөрөөр хэлбэл ... Нэг талаас Засгийн газар, аймаг нийслэлийн засаг дарга, компани хувьцаа, бонд гарган худалдах замаар өөрт шаардлагатай байгаа хөрөнгийг татдаг, нөгөө талаас хөрөнгөө өсгөх сонирхолтой байгууллага, хувь хүмүүс үнэт цаас худалдан авдаг зах зээлийг хэлнэ.

Засгийн газар, аймаг, нийслэлийн засаг дарга төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр харин компани шинэ бизнес эхлэх болон бизнесээ өргөжүүлэхээр хувьцаа болон бонд гаргадаг.

Хөрөнгө оруулагч гэдэг нь тэрхүү хувьцаа, бондыг худалдан авч байгаа талыг хэлдэг. Үүнд та ч бас багтана.

Хөрөнгийн зах зээл гэдэг нэр томъёо нь үнэт цаасны зах зээлээс өргөн харилцааг агуулсан ойголт гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Хөрөнгийн зах зээлд дээрхээс гадна үл хөдлөх хөрөнгийг зуучлах, худалдах, худалдан авах зэрэг харилцаа багтдаг.

Тиймээс энэхүү номонд үнэт цаасны зах зээл гэдэг нэр томъёог ашиглав.

БҮЛЭГ IV

**БОНДЫН
ҮР АШИГ**

БОНД ГЭЖ ЮУГ ХЭЛДЭГ ВЭ?

Бондыг өрийн бичиг гэж ойлгож болно.

Бонд бол тогтмол орлоготой, эрсдэл багатай үнэт цаас юм.

Тодруулж хэлбэл ... Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүгээ эргүүлэн авдаг үнэт цаас. Ингэхдээ төлбөрөө мөнгө, хувьцаа, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн авч болдог.


Та бонд худалдан авна гэдэг нь тухайн компанид тодорхой хугацаатай, тогтсон хүүгээр мөнгө зээлж байгаатай адил. Үүгээрээ хувьцаанаас ялгаатай.

Бондын гол өгөөж нь хүү байдаг. Бондын хугацаа дуусмагц **үндсэн мөнгөө хүүгийн хамт** эргүүлэн авна.

Бонд нь хувьцаатай адил урт хугацаатай үнэт цаас бөгөөд хугацааны хувьд дараахь байдлаар ангилдаг. Үүнд:

- Богино хугацаа - 1-ээс 3 хүртэлх жил
- Дунд хугацаа - 3-аас 5 хүртэлх жил
- Урт хугацаа - 5-аас дээш жил

Хэрвээ ... Танд мөнгө хэрэг болвол хувьцаатай адил бондоо хоёрдогч зах зээл дээр борлуулж болно.



Бондыг Засгийн газраас мөн орон нутгийн засаг захиргаанаас төсөл хөтөлбөр болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргадаг. Харин компаниудын хувьд хөрөнгө босгож бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэх зорилгоор гаргана.

Бонд гаргах нь хувьцаа гаргахтай адил хөрөнгө босгох нэгэн арга юм.

БҮЛЭГ V

**ТА БА
ТАВАН
ТОЛГОЙ**

ТАНЫ МЭДЭХ УЧИРТАЙ ТАВАНТОЛГОЙ



Таныг хувьцааны дансандаа **Эрдэнэс Тавантолгойн 1072 хувьцаатай**, мөн үнэт цаасны зах зээлийн тухай **бага ч болов мэдлэгтэй болсон** гэж найдаж байна.

“Одоо харин ... Хувьцааг нь эзэмшиж буй компанийнхаа тухай мэдээлэлтэй болох нь чухал. **Учир нь үнэт цаасны зах зээл дээр таны барих “зэвсэг” бол мэдээлэл юм.**

Өргөн мэдээлэлтэй хөрөнгө оруулагч ирээдүйг төсөөлж чадах нь тодорхой билээ.

УИХ-ын 2010 оны 39-р тогтоол болон Засгийн газрын 2011 оны 3-р сарын 31-ний 98-р тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 10 хувийг Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр заасан.

Мөн УИХ-ын 2012 оны 2-р сарын 16-ны 18-р тогтоолоор “Эрдэнэс Тавантолгойн” хувьцааны 20 хүртэлх хувийг буюу нэмж 10 хувийг иргэдэд эзэмшүүлэхээр болсон билээ.

Монгол Улс ашигт малтмалын нөөцөөр ялангуяа Тавантолгой ордоор дэлхийд танигдаж байна.

Эх орныхоо байгалийн баялаг,
эдийн засгийн өсөлт, хөгжлөөс

**ЭЗНИЙ ЁСООР ХҮРТЭХ
ХҮН БҮРИЙН БОЛОМЖ БОЛ
ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ЮМ.**

“Хувьцаа худалдан авч, худалдаж, орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, бүр цаашлаад асар их хөрөнгийн эзэн болоход танд хамгийн эхлээд зөв мэдээлэл, дараа нь таны хүсэл тэмүүлэл чухал гэдгийг давтан хэлэхийн зэрэгцээ энэ бол хэн нэгэн тусгай хүн юм уу, бизнесменүүдийн ярьдаг, хийдэг ажил биш гэдгийг сануулъя.”

Энэ бол Та хүссэнээрээ амьдрах, таны үр хүүхэддээ нүүр бардам үлдээх өв хөрөнгө, ур чадвар, туршлага юм.

Танд амжилт хүсье!



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ

Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилерийн компани



Үнэт цаасны зах
зээлд оролцож
хөрөнгөө өсгөн
аз жаргалтай
амьдрахыг хүсч
буй хүн бүрт ...

Эрхэм уншигч ТАНД “Хувьцааны
цагаан толгой” номоо уншиж,
үнэт цаасны зах зээлийн тухай
мэдлэгээ зузаатгахын зэрэгцээ
номоо авчран хувьцааны дансаа
үнэгүй нээлгэх боломжийг
олгож байна.

Утас: 7011 4433, 9907 2694

Э-шуудан: broker@standardinvestment.mn

Вэб хаяг: www.standardinvestment.mn

Овог:

Нэр:

Регистр:

Утас:

И-мэйл:

Та Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааг хэрхэн
ашиглах вэ?

- ☐ Хадгалж ногдол ашиг авна.
- ☐ Хадгалж компанийн үйл ажиллагаанд
хяналт тавих, санал өгөх эрхээ хэрэгжүүлнэ.
- ☐ Үнэд хүргэж зарна.

Монголын
түүхийн музей

Улаанбаатар
хотын банк

Засгийн газрын
ордон

Сүхбаатарын
талбай

МОНЦЭМЭ агентлаг

Индра
Fast food

Монголын Үйлдвэрчний Эвлэл



Стандарт
Инвестмент

Broadway
ресторан

Хангарьд
ордон



Стандарт Инвестмент ХХК нь Монголын үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн биржийн гишүүн, Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Та ямар тохиолдолд хувьцаагаа зарах вэ?

.....
.....
.....

Та өөр ямар салбар, компанийн хувьцаа худалдаж авахыг сонирхож байна вэ?

1.
2.
3.

UB Palace

25-р эмийн сан

Кёокушу
цамхаг



Стандарт Инвестмент
Стандарт Финанс



25-р эмийн са

Энхтайваны өргөн чөлөө

УБТЗ
эмнэлэг





СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ

Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилерийн компани

СТАНДАРТ САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Бид санхүүгийн соёлыг түгээнэ



Энэхүү номыг худалдан авснаар та санхүүгийн мэдлэгээ дээшлүүлэхээс гадна үнэт цаасны дансаа үнэгүй нээлгэх эрхтэй болно. Стандарт Инвестмент ХХК танд энэ эрхийг олгож байна.

ISBN 999-62-61-1-5



9 789996 261435

